



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 381

Улаанбаатар хот

### Даатгалын компанийн бүтээгдэхүүнийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.7.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Миг даатгал” ХХК-ийн “Жолоочийн гэнэтийн ослын даатгал”-ын бүтээгдэхүүнийг хавсралтад заасны дагуу бүртгэсүгэй.

2. Даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралтын 4.7.1-д “... Бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүний нөхцөл шаардлага бүхий загвараар тухайн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулна” гэж заасныг мөрдөж ажиллахыг “Миг даатгал” ХХК /Б.Мөнххишиг/-д үүрэг болгосугай.

3. Хавсралтад дурдсан бүтээгдэхүүний гэрээнд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай заалт, мэдээлэл тусгасны улмаас даатгуулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Миг даатгал” ХХК /Б.Мөнххишиг/, актуарч /Ч.Баттүшиг/-д тус тус анхааруулсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны  
2019 оны 11 сарын 16 өдрийн  
381 –р тогтоолын хавсралт



Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

1.	Даатгалын компанийн нэр:	“Миг даатгал” ХХК
2.	Даатгалын бүтээгдэхүүний нэр:	Жолоочийн гэнэтийн ослын даатгал
3.	Хамаарах даатгалын хэлбэр:	Гэнэтийн осол эмчилгээний даатгал
4.	Даатгалын зүйл	Жолоочийн амь нас, эрүүл мэнд
5.	Даатгалын эрсдэл	Даатгуулагч нь тээврийн хэрэгслийг жолоодон замын хөдөлгөөнд оролцож байх үедээ өөрийн буруутай үйлдлийн улмаас зам тээврийн осол гарган өөрийн эрүүл мэндэд хохирол учруулах
6.	Даатгалын гэрээний хугацаа	1 жил
7.	Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо	11 бүлэг, 68 заалт
8.	Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр:	“Миг даатгал” ХХК-ийн гүйцэтгэх хорооны хурлын 2019 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн шийдвэр.
9.	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Ч.Баттүшиг
10.	Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:	Даатгал хариуцсан дэд захирал Д.Долгор, Даатгалын андеррайтер Э.Мөнхтөр, Б.Чимэдбадрах, Б.Цэлмүүн, Б.Хатанбүүвэй